

## **“Оюу толгой” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Батсүхийн хэлсэн үг**

**Монгол Улс, Улаанбаатар хот - 12 дугаар сарын 16, 2015**

### **Төслийн санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурах ёслолын үеэр “Оюу толгой” компанийн ТУЗ-ийн дарга Г.Батсүхийн хэлсэн үг**

Эрхэм хүндэт хатагтай ноёд оо, “Оюу толгой”-н түүхэнд шинэ хуудас нээж буй энэ онцгой үйл явдалд та бүхнийг хүлээн авах хүндэт үүрэг надад тохиосонд миний бие туйлын их баяртай байна.

Өнөөдөр зөвхөн “Оюу толгой”-д төдийгүй, Монголын ард түмний хувьд онцгой, чухал өдөр тохиож байна гэдэгт би итгэлтэй байна.

Хүрэл зэвсгийн үеэс эхлэн одоогийн Өмнөговь аймгийн газар нутагт амьдарч ирсэн нүүдэлчид өнөөгийн Оюу толгой хэмээн нэрийдсэн газраас зэс илрүүлэн, түүнийгээ боловсруулж, аж амьдралдаа ашиглаж байсан цаг үеэс эхлээд өнөөг хүртэл үргэлжилж буй баялаг түүх бидэнд бий.

1997 оны өргөн хүрээтэй хайгуулын ажлын үр дүнд Д.Гарамжав, С.Санждорж, Деннис Кокс, Т.Мөнхбат болон геологич Г.Оюун нар Өмнөд Оюугаас кварцын судлууд илрүүлжээ. Тэд кварцын судлууд олдсон талбайд гурван овоо босгож тэмдэглээд орхисон нь хожим “Алтан гурвалжин” хэмээгдэх болсон билээ.

Эрлийн багийнхан зургаан ерөм тавьсны нэг нь “Алтан гурвалжин” дотор байв. Сүүлд яг тэнд тавьсан гүний ерөмдлөгөөр Өмнөд Оюугийн орд газрын эрдэсжсэн хэсэгт анх хүрч, Оюу толгойн их ордыг дэлхий нийтэд ил болгосон юм.

Эрлийн багийн гишүүдээс Т.Мөнхбат, Д.Гарамжав, С.Санждорж нар өдийг хүртэл Оюу толгойн уурхайдаа ажилласаар байгааг дуулгахад таатай байна.

Ордыг нээн илрүүлсэн тэдгээр гавьяатнууд болон Оюу толгойн нийт хамт олныг төлөөлөн би Оюу толгойн өнөөг хүртэл хүрсэн амжилтаар туйлын их бахархаж байна.

Оюу толгойн уурхайн бүтээн байгуулалтын ажил 2010 онд буюу дөнгөж таван жилийн өмнө эхэлж байсныг дурдах нь зүйтэй.

Барилга бүтээн байгуулалтын ажил 2010-2013 оны хооронд хурдацтай, амжилттай явагдаж, Монгол Улсын түүхэн дэх хамгийн томоохон бүтээн байгуулалтын нэгийг бид босгож чадсан юм.

Монгол орны хамгийн алслагдмал нутагт орших энэ уурхайн бараг бүх барилга байгууламжийг урьд нь аливаа барилга байгаагүй хоосон газарт барьж, машин техник ажиллуулж, улмаар бүхэл бүтэн үнэ цэнийн хэлхээг бий болгосон билээ.

Аварга том ачааны машин, алганд багтах боолт, уурхайчдын ажлын хувцас, уух ус, хоол хүнс гээд бүх зүйлийг дотоодоосоо, мөн гадаадаас авчирч энэ нүсэр бүтээн байгуулалтыг гүйцэтгэж, Оюу толгойн уурхайг барьж байгуулсан түүхтэй.

Монголын болон гадаадын 40 гаруй орны ажилчдын нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлийн дүнд говийн хөрснөө жигдхэн хөх өнгөтэй аварга том барилга байгууламжууд, агуулах савнууд, уурхайн цамхгууд бүхий аж үйлдвэрийн цогцолбор сүндэрлэн босов.

Төд удалгүй Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх хамгийн том баяжуулах үйлдвэрийн суурийг тавьсан.

Нэг хоногт 100 мянган тонн хүдэр боловсруулах чадалтай энэ үйлдвэр өнөөдөр үйл ажиллагаагаа жигдрүүлээд, мэргэшсэн боловсон хүчний авьяас, шинийг санаачлах чадварын ачаар аюулгүй ажиллагаандаа аливаа доголдолгүйгээр үйлдвэрлэлийнхээ дээд хэмжээг шинэчлэн тогтоосоор байна.

Уурхайн бүтээн байгуулалт хурдацтай, амжилттай явагдсаны дараагаар баяжуулах үйлдвэрийг анх 2012 онд ажиллуулж эхэлж байсан.

Оюу толгойн уурхай ердөө хоёр жилийн өмнө буюу 2013 оны сүүлчээр бүтээгдэхүүнээ анх зах зээлд нийлүүлсэн.

Энэ 12 дугаар сард бид баяжуулах үйлдвэрээ ажиллуулж эхэлсний гурван жилийн ойг тэмдэглэж байна.

Энэ богино хугацаанд бид хөрш зэргэлдээх орон нутагтайгаа бат бэх, харилцан нэг нэгнээ дэмжсэн харилцааг бэхжүүлж ирлээ.

Бид энэ оны эхээр Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, болон Даланзадгад сумдтай Хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Бидний урт хугацааны тогтвортой хамтын ажиллагаандаа баримтлах зарчим, үнэт зүйлс, үүрэг хариуцлага энэхүү гэрээнд тусгагдсан.

Энэ бүгд нь “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэх” гэсэн манай компанийн алсын хараанд суурилсан болно.

Хэдийгээр манай Монгол Улс дэлхийн хамгийн их нөөц баялагтай орнуудын нэгт тооцогддог боловч бид илүү том дүр зургийг эндээс олж харах хэрэгтэй. Уул уурхайн дэвшилтэт технологи, орчин үеийн шинэлэг үйл ажиллагаа нь манай орны хувьд шинэ зүйл юм.

Компанийн хувьд бид зөвхөн Оюу толгойд биш, дэлхийн стандартыг давсан ур чадвар, мэргэшлийг бий болгож, улс оронтойгоо хамтдаа өсөн дэвжих үүрэг хариуцлагыг хүлээсэн.

Компанийн ажиллах хүчний 95 гаруй хувийг монгол ажилтнууд бүрдүүлж байгаагаар би бахараж байна. Өнгөрсөн жил манай компанийн нийт худалдан авалтын 80 хувийг дотоодын ханган нийлүүлэгчид бүрдүүлсэн байна. Үйл ажиллагаагаа эхлүүлээд, зах зээлд хөл тавиад төдийлөн удаагүй байгаа бизнесийн хувьд эдгээр үзүүлэлт нь өндөр амжилт бөгөөд манай компани Монголын бизнесийн талбарт өсөн дэвжиж буй Монгол компанийн тод жишээ болж байна.

Энэ нь яг юу гэсэн утгатай үг болох тухай та бүхэнд хэлье.

2014 онд “Оюу толгой” ойролцоогоор 1000 гаруй дотоодын ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласан бөгөөд тэдгээр аж ахуйн нэгжүүдийн ард 35 мянга гаруй ажилчин, тэдний гэр бүлийнхэн нь бий.

Манай улсын нийт хүн амын тоо ердөө гурван сая шүү дээ.

Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт таваас долоон жилийн хугацаанд үргэлжилж, оргил үедээ 3000 ажилтан авч ажиллуулна. Энэхүү ажиллах хүчний ихэнхийг дотоодын чадварлаг боловсон хүчин бүрдүүлнэ.

Өнөөг хүртэл судалсаар байгаа, газрын зурагт зураад байгаа Оюу толгойн орд газрын нийт нөөц нь зуу гаруй жил уурхайн үйл ажиллагааг явуулах боломжтойг илтгэн харуулж байгаа нь манай бизнест олон үе дамжсан томоохон үйлдвэрлэлийг бүтээн босгох боломж байгааг нотолж байна.

Энэ нь манай хувь нийлүүлэгчид, Монгол Улсын Засгийн газарт асар их үнэ цэнийг авчрах болно.

Бид “Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна” гэсэн эрхэм зорилгыг урдаа тавин ажилладаг.

Оюу толгойг дэлхийн хамгийн шилдэг зэсийн уурхайнуудын нэг болгох замналд дэмжлэг үзүүлж, манай орны бодит хөгжил, эдийн засгийн өсөлт, хөгжил цэцэглэлт авчрахад туслах энэ аянд бид өнөөдөр нэгдээд байна.

“Оюу Толгой”-н хамт олон, халуун дотно гэр бүлийн нэрийн өмнөөс манайд тавтай морилно уу гэж та бүхэнд хэлье. Та бүхний хичээл зүтгэлд баярлалаа.

Монголчууд бид “Эзэн хичээвэл заяа хичээнэ” гэж хэлдэг. Бид хамтдаа шаргуу ажиллаж, улам илүү амжилтад хүрэх болно.

Баярлалаа.